

Булган аймгийн Бугат сумын боксын "Бугат" клубын нэрэмжит олон хотын холимог насны тэмцээн Бугат суманд 2018 оны 01 дүгээр сарын 05-09-ны өдрүүдэд зохион байгуулагдлаа. Тус тэмцээнд 22 байгууллагын 200 гаруй тамирчид 63 багц медалийн төлөө өрсөлдөж Багийн дүнгээр I байр "Хангарьд" клуб, II байр "Бугат" клуб III байр "Ихэр бээлий" багийн тамирчид тус тус шалгарсан байна.



Булган аймгийн Тэшиг суманд "Анхдагчдын цом-2018" гүйлтийн цанын нээлттэй тэмцээн, Баруун бүсийн аварга шалгаруулах өсвөр цаначдын тэмцээнүүд амжилттай зохион байгуулагдлаа. Тэмцээнд Булган, Булган аймгийн Тэшиг сумын Хилийн цэргийн 0286 дугаар анги, Орхон, Хэнтий, Дархан, Өвөрхангай, Сүхбаатар, Хилийн цэргийн 0303 дугаар тусгай салбар, Монголын цанын холбооны дэргэдэх спортын төв, Орхон аймгийн "Цасан зам" клуб тус тус оролцлоо.

Тэмцээний насанд хүрэгчдийн насны ангилалд 42 тамирчин, өсвөр насны ангилалд 76 тамирчин нийт 118 тамирчин хурд, хүч, авхаалж самбаагаа сорин өрсөлдлөө. Өсвөр цаначид багийн дүнгээр: Тэргүүн байр Ю.Соёлмаа дасгалжуулагчтай Булган аймгийн I баг, Дэд байр П.Баярсайхан дасгалжуулагчтай Булган аймгийн II баг, Гутгаар байр Батдорж дасгалжуулагчтай Өвөрхангай аймгийн баг тамирчид Насанд хүрэгчид багийн дүнгээр: Тэргүүн байр Хэнтий аймаг, Дэд байр Хилийн цэргийн 0303 дугаар тусгай салбар, Гутгаар байр Хилийн цэргийн 0286 дугаар анги тус тус шалгарсан байна.



Аймгийн Засаг даргын 2018 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн А/259 тоот захирамжийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд "Булган марафон-2018" бүх нийтийн гүйлтийн нээлттэй тэмцээнийг зохион байгууллаа. Тэмцээнийг АЗДТГазар, Булган сумын ЗДТГазар, БТСГазар, Булган аймгийн хөнгөн атлекийн холбоо, Эрүүл мэндийн газар, ОБГазар, Цагдаагийн газар, ХЖТеатр хамтран зохион байгууллаа. Тэмцээнийг 12-17 нас эр, эм 5000м, 18-34 нас эр 10000м, эм 5000м, 35-49 нас эр, эм 3000м, 50 –иас дээш нас эр, эм 2000м, 21 км-т 18-49 нас эр, эм, 50-иас дээш нас эр, эм гэсэн зайн төрлүүдээр зохион байгуулж аваргуудыг шалгарууллаа. Тэмцээнд Улаанбаатар хот, Орхон, Хөвсгөл, Увс, Архангай, Баянхонгор, Булган, Завхан аймаг Булган аймгаас Тэшиг, Сайхан, Хутаг-Өндөр, Хялганат, Баян-Агт, Булган сум Булган сумаас 46 байгууллага, нийт 70 гаруй байгууллагын 900 гаруй тамирчид оролцлоо.



"Хөдөөгийн хүчтэн" Төвийн бүсийн аварга шалгаруулах барилдааны сонгон шалгаруулах "Сорилго барилдаан" амжилттай боллоо. Тус барилдаанд 30 бөх тойргийн журмаар барилдаж эхний 8 байрыг шалгарууллаа. Эхний 5 байранд шалгарсан бөхчүүд Төвийн бүсийн аварга шалгаруулах

Үндэсний спортын наадмын хүрээнд:Тус наадмыг өвөл зуны гэсэн төрлүүдээр зохион байгуулан явуулж байна.

Үндэсний Спортын VI их наадам, “Монгол нум сум” дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлуудын хүрээнд “Хангинахын шугуйн шагайн тойром” Сурын харваа, Шагайн харваан тэмцээнүүдийг Хутаг-Өндөр сумын “Гуртын хөтөл”-д 2018 оны 06 дугаар сарын 02-03-ны өдрүүдэд урлаг соёлын арга хэмжээгээр эхэлж, нээлтийн арга хэмжээг Ц.Бат-Өлзий /Аймгийн Засаг даргын орлогч/ нээж, П.Итгэлбаяр /Хутаг-Өндөр сумын Засаг дарга/, А.Ханддорж /Биеийн тамир, спортын газрын дарга/ болон бусад албаны хүмүүс нээлтийн арга хэмжээнд оролцож, хамтран зохион байгуулагчаар Аймгийн Засаг даргын тамгын газар, БТСГазар, БОАЖГазар, Хутаг-Өндөр сумын ЗДТГазрууд ажиллаа. Сурын харваанд тэмцээнийг Үндэсний сур, Буриад сур, Уламжлалт сур, Урианхай сурын харваан төрлүүдээр зохион байгуулснаас нийт: 6 багийн 48 харваачид үүнээс: Спортын



мастер-3, спортын дэд мастер -
1, Урианхай сурын спортын мастер-1, спортын дэд мастер-1, Аймгийн мэргэн-5, Сумын мэргэн-7 оролцлоо. **Үндэсний сурын багийн харваанд** I байранд Спортын мастер, Аймгийн мэргэн Д.Мөнхдорж ахлагчтай “Баатар ван”II, байранд Спортын мастер, Аймгийн гарамгай мэргэн Д.Галбадрах ахлагчтай “Жинст” багIII байранд С.Ганбат ахлагчтай Баян-Агт баг **Урианхай сурын харваанд** :I байранд М.Болд ахлагчтай “Дархан баг”II байранд Г.Ууганбаяр ахлагчтай “Жинст” багIII байранд С.Ганбат ахлагчтай Баян-Агт баг **Буриад сурын харваанд** :I байранд Г.Ууганбаяр ахлагчтай “Отго жинст” багII байранд Д.Мөнхдорж ахлагчтай “Жинст” багIII байранд Д.Галбадрах ахлагчтай “Дархан” баг **Уламжлалт сурын харваанд** :I байранд Д.Галбадрах ахлагчтай “Дархан” багII байранд Г.Ууганбаяр ахлагчтай “Отго жинст” багIII байранд Д.Мөнхдорж ахлагчтай “Жинст” баг **Цуваа харвааны эрэгтэй**:I байранд Спортын дэд мастер, Аймгийн хошой мэргэн Г.Ууганбаяр /Бүрэгхангай сум/II байранд Залуу харваач Д.Мөнх-Эрдэнэ /Бүрэгхангай сум/III байранд Залуу харваач А.Лувсансүрэн /Бүрэгхангай сум/IV байранд Спортын мастер, Аймгийн мэргэн Д.Мөнхдорж /Бүрэгхангай сум/V байранд Спортын мастер М.Болд /Бүрэгхангай сум/ **Цуваа харвааны эмэгтэй**:I байранд Спортын мастер, Аймгийн гоц мэргэн Л.Энхзул /Бүрэгхангай сум/II байранд Сумын мэргэн Д.Саранчимэг /Бүрэгхангай сум/III байранд Аймгийн мэргэн Б.Цэнгэлмаа /Бүрэгхангай сум/IV байранд Залуу харваач Ц.Баярмаа /Бүрэгхангай сум/V байранд Залуу харваач Д.Бат-Өлзий /Бүрэгхангай сум/ тус тус шалгарсан байна.